

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ийн  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: НТАГ-2026/129/НА-СТА-ОНӨҮГ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г. Надинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: <a href="mailto:nandinjargalg@audit.gov.mn">nandinjargalg@audit.gov.mn</a></p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:gantugss@audit.gov.mn">gantugss@audit.gov.mn</a></p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-ийн захирал: Д.Баатарсайхан Утас: 9909-9119 Цахим хаяг: <a href="mailto:gerelthuhaudit@gmail.com">gerelthuhaudit@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.1 Компани /ТӨҮГ/, түүний үйл ажиллагаа .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	<b>Error! Bookmark not defined.</b>
3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.1 Ерөнхий зүйл.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.2 Материаллаг байдал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	<b>Error! Bookmark not defined.</b>
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .	<b>Error! Bookmark not defined.</b>
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	7
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	9

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-13 № 102  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙТЛЭГ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА  
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА  
Б.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг байдлын үүднээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Хан-Уул дүүргийн ИТХ-ын 2024 оны 13 дугаар тогтоолоор Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд орлого 3,423.0 сая төгрөгөөр батласнаас гүйцэтгэлээр 5,387.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,906.2 сая төгрөг буюу 64,62 хувиар давсан нь нүхэн гарцын арчлалт болон авто зогсоол хариуцан ажлуулах шинэ нэр төрөлийн ажил нэмэгдүүлсэн нь нөлөөлжээ.

### Аудитын гол асуудал

Нийтлэг үйлчилгээний алба нь дүүргийн гадна талбайн авто машины зогсоолын төлбөрийн орлогоос 87.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн ба үүнийг 40 хувь болох 37.7 сая төгрөгийг Замын хөдөлгөөний удирдлагын төвийн дансанд шилжүүлсэн байна.

1426350838

C:\Users\aranga\Desktop\Бичр хэрг 2025\20250313\Хан-Уул дүүргийн Нийтлэг 2025.docx

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 89.9 хувийн хэрэгжилттэй гүйцэтгэсэн гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	262,854,092.36	285,327,375.38
Дансны авлага	207,832,634.71	64,851,743.65
Татвар, НДШ – ийн авлага	71,186,663.73	85,369,119.16
Бараа материал	359,843,393.94	793,367,966.93
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>901,716,784.74</b>	<b>1,228,916,205.12</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>47,964,452.87</b>	<b>88,277,563.05</b>
Үндсэн хөрөнгө	47,964,452.87	86,890,896.41
Биет бус хөрөнгө	-	1,386,666.64
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>47,964,452.87</b>	<b>88,277,563.05</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>949,681,237.61</b>	<b>1,317,193,768.17</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг	14,974,744.05	715,145.88
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>14,974,744.05</b>	<b>715,145.88</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>14,974,744.05</b>	<b>715,145.88</b>
<b>Эздийн өмч</b>		
Өмч: -төрийн	-	-
Хуримтлагдсан ашиг	934,706,493.56	1,316,478,622.29
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>934,706,493.56</b>	<b>1,316,478,622.29</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>949,681,237.61</b>	<b>1,317,193,768.17</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>3,308,070,944.56</b>	<b>4,257,417,300.01</b>
	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>4,257,417,300.01</b>	<b>4,257,417,300.01</b>
3	Хүүгийн орлого	7,519,322.26	2,639,476.13
6	Бусад орлого	521,125,849.64	634,483,485.50
7	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
8	Ерөнхий ба удирдлагын зардал	3,333,861,809.06	4,470,349,007.50
	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>502,854,307.40</b>	<b>424,191,254.14</b>
19	Орлогын татварын зардал	50,285,430.74	42,419,125.41
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>452,568,876.66</b>	<b>381,772,128.73</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	-	-
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>452,568,876.66</b>	<b>381,772,128.73</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>452,568,876.66</b>	<b>381,772,128.73</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>4,220,088,276.30</b>	<b>5,387,302,242.46</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,220,088,276.30	5,387,302,242.46
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>4,233,839,912.43</b>	<b>5,297,882,817.62</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,309,743,617.01	1,712,255,728.89
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	186,582,268.61	212,609,376.63
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	54,422,940.00	186,524,829.68
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	183,815,140.65	230,930,490.78
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	472,519,607.54	567,437,820.87
1.2.10	Бусад мөнгөн зарлага	2,026,756,338.62	2,388,124,570.77
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(13,751,636.13)</b>	<b>89,419,424.84</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>14,067,999.99</b>	<b>66,946,141.82</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,067,999.99	66,946,141.82
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(14,067,999.99)</b>	<b>(66,946,141.82)</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(27,819,636.12)</b>	<b>22,473,283.02</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>290,673,728.48</b>	<b>262,854,092.36</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>262,854,092.36</b>	<b>285,327,375.38</b>

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	-	-	482,137,616.90	482,137,616.90
3	Залруулсан үлдэгдэл	-	-	482,137,616.90	482,137,616.90
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	452,568,876.66	452,568,876.66
9	2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	-	-	934,706,493.56	934,706,493.56
11	Залруулсан үлдэгдэл	-	-	934,706,493.56	934,706,493.56

Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	381,772,128.73	381,772,128.73
17	<b>2025 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	-	<b>1,316,478,622.29</b>	<b>1,316,478,622.29</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт		2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Борлуулалтын орлого</b>	<b>3,481,017,300</b>	<b>5,387,302,240</b>	<b>1,906,284,940</b>	<b>154.7</b>
	Үйл ажиллагааны бус орлого	-	-	-	-
	<b>Нийт орлого</b>	<b>3,481,017,300</b>	<b>5,387,302,240</b>	<b>1,906,284,940</b>	<b>154.7</b>
2	Үндсэн болон нэмэгдэл цалин	1,607,259,700	1,924,865,100	317,605,400	119.7
	Нийгмийн даатгалын шимтгэл	200,907,300	232,003,980	31,096,680	115.5
	Бичиг хэрэг	7,500,200	8,542,280	1,042,080	113.9
	Гэрэл цахилгаан	215,000,000	109,990,670	105,009,330	51.1
	Түлш халаалт	108,000,000	56,508,180	51,491,820	52.3
	Цэвэр бохир ус	99,000,000	64,431,620	34,568,380	65.1
	Тээвэр, шатахуун	20,000,000	15,700,000	4,300,000	78.5
	Шуудан холбоо	8,500,000	4,061,530	4,438,470	47.8
	Ном хэвлэл	500,000	0.00	500,000	0
	Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,000,000	62,615,250	22,615,250	156.5
	Урсгал засвар, тавилга эд хогшил	499,402,000	1,369,088,600	869,686,600	274.1
	Бараа үйлчилгээний бусад зардал	25,000,000	31,134,010	6,134,010	124.5
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	574,948,100	1,345,908,790	770,960,690	234.1
	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	75,000,000	73,032,800	1,967,200	93.4
	<b>Нийт зардал</b>	<b>3,481,017,300</b>	<b>5,297,882,810</b>	<b>1,816,865,510</b>	<b>152.2</b>
Татварын дараах ашиг (алдагдал)					
	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал				
	Авлага	3,975,350	161,063,170	157,087,820	4,051.5
	Өглөг	32,156,820	715,140	31,441,680	2.2

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 25,362.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 1 албан шаардлага 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт залруулагдаагүй 25,362.8 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшин 42,574,2 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

### **1 Албан шаардлага**

Авлагыг үлдэгдэл 288.0 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх"; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулдаггүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлсэн

### **2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Орлого тооцохтой холбоотой асуудал**

Илрүүлэлт-1: Тайлант үеийн орлогыг НӨАТ-ын тайланд 25,074.8 мянган төгрөгөөр давхардуулан нэмэгдүүлж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 зүйл 5.1.4 Үнэн зөв байх, НӨАТ тухай хуулийн 7 дугаар зүйл 7.3.2.борлуулалтыг аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд хийсэн байх. гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын бүртгэлийг холбогдох тайлангуудтай уялдуулан тайлагнах;

#### **2. Эд хариуцагчтай холбоотой асуудал**

Илрүүлэлт-2: Эд хариуцагчийн картанд хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр шинэчилж хөтлөөгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйл. 2/ "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам,

заавар" гэсэн заалттай нийцээгүй байна санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Эд хариуцагчийн картад хөрөнгийн нэмэгдэх болон хасагдах хөдлөл бүрд баяжилт тогтмол хийх:

Дээрх аудитын шийдвэрийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант үеийн орлогыг НӨАТ-ын тайланд давхардуулан нэмэгдүүлж тайлагнасан байна	1	25,074.8					1	25,074.8
Эд хариуцагчийн картанд хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр шинэчилж хөтлөөгүйгээс хөрөнгө солигдох эрсдэлтэй байна.	1						1	
Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	288.0			1	288.0		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>25,362.8</b>			<b>1</b>	<b>288.0</b>	<b>2</b>	<b>25,074.8</b>





НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 552/14810519

Улаанбаатар хот

НТАА-2026/129/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд тусгагдсан авлагаас 288,000 (хоёр зуун наян найман мянган төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, бодитой эсэх нь нотлогдоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, актаар баталгаажуулдаггүй зөрчлийг арилган, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх таслан зогсоож, биелэлтийг ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хан-Уул дүүргийн дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ийн гүйцэтгэх захирал (Б.Мөнх-Эрдэнэ), ерөнхий нягтлан бодогч (Э.Солонго) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨРСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР  
АУДИТ ХХК ЗАХИРАЛ



Г.НАНДИНЖАРГАЛ  
С.ГАНТӨГС  
Д.БААТАРСАЙХАН

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426091017

